МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ТОГТООЛ

2026 оны 04 сарын 15 өдөр Дугаар 134 Улаанбаатар хот

Эрүүл мэндийн салбарт авч хэрэгжүүлэх
арга хэмжээний тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг, үндэслэн Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор батлсан "Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.Эрүүл мэндийн салбарын үйл ажиллагааны үр дүн, зохион байгуулалтыг сайжруулах чиглэлээр доор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Эрүүл мэндийн сайд Э.Батшугарт даалгасугай:

1.1.Эрүүл мэндийн байгууллагын зохион байгуулалт, менежмент, үр ашгийг сайжруулж, санхүүжилтийг ажлын гүйцэтгэл, үйл ажиллагааны үр дүнтэй уялдуулах, цалин урамшууллын тогтолцоог боловсронгуй болгох, холбогдох журам, дүрэм, аргачлалыг шинэчлэн баталж, хэрэгжүүлэх;

1.2.зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалтыг шинэчилж, эм, эмнэлгийн хэрэгслийн хангамж, хүртээмжийг нэмэгдүүлэх, нэгдсэн худалдан авалтыг өргөжүүлж, нийлүүлэлтийн тасралтгүй байдлыг хангах, эмийн чанар, аюулгүй байдлын хяналтын тогтолцоог олон улсын жишигт нийцүүлэн бэхжүүлэх, эмийн хяналтын лабораторийг олон улсын итгэмжлэлд нийцүүлэн хөгжүүлэх, шаардлага хангахгүй эмийг эрт илрүүлж зах зээлээс татан авах, чанар, стандартын шаардлага хангасан эмийг үйлдвэрлэгчээс шууд худалдан авах механизмыг үе шаттай нэвтрүүлэх;

1.3.анхан шатны тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, шатлал хоорондын уялдааг сайжруулж, хүний нөөцийг бэхжүүлэх замаар лавлагаа шатлалд үүсэх ачааллыг бууруулах арга хэмжээ авах;

1.4.эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний шатлалын тогтолцоог оновчтой тодорхойлж, эмнэлгийн бүтэц, зохион байгуулалтыг сайжруулах замаар төсөв хуваарилалтын үр ашгийг нэмэгдүүлэх, иргэн, даатгуулагч шаардлагатай тусламж, үйлчилгээг саадгүй, шуурхай хүртэх нөхцөлийг бүрдүүлэх;

1.5.эрүүл мэндийн байгууллагын засаглал, гүйцэтгэлийн үнэлгээ, өр төлбөртэй холбоотой асуудлаар үйл ажиллагаанд нь хяналт шалгалт хийж, засаглал, хариуцлагыг сайжруулах арга хэмжээг 2026 онд багтаан авч хэрэгжүүлэх, хэрэгжилтийг танилцуулах;

1.6.төрийн өмчит эрүүл мэндийн байгууллагуудын лаборатори, цахилгаан, сантехник, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ, угаалга, ариутгал, хоол үйлдвэрлэл зэрэг үйл ажиллагааг хувийн хэвшлээр, гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж, орон тоог бууруулах, үйл ажиллагааны үр ашигтай байдлыг сайжруулах;

1.7.эрүүл мэндийн салбарт мөрдөгдөж байгаа тусгай зөвшөөрөл, стандарт, заавар, аргачлал (удирдамж)-д дүн шинжилгээ хийж, давхардсан зохицуулалт, бичиг баримт, хяналт шалгалтыг арилгах, холбогдох стандарт, журам, дүрэм, заавар аргачлалыг шинэчлэх, хүчингүй болгох, эмнэлзүйн зааврын хэрэглээг сайжруулахтай холбоотой арга хэмжээг үе шаттай авч хэрэгжүүлэх;

1.8.2027 оныг "Эрүүл мэндийг дэмжих жил" болгон зарласантай холбогдуулан эрүүл мэндийн салбарын хууль, эрх зүйн орчныг шинэчлэлийг эрчимжүүлэх хүрээнд холбогдох хууль тогтоомжийн төслийг боловсруулж, 2026 оны 3 дугаар улиралд багтаан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх;

1.9.эмнэлгийн тусламж, үйлчилгээнд ашиглаж байгаа мэдээллийн бүртгэл, мэдээлэл солилцоо, өгөгдөл хадгалалт, цаасан суурьтай үйл ажиллагааг бүрэн цахимжуулж, чиг үүргийн давхардлыг арилгах замаар эмч, эмнэлгийн ажилтнуудын ажлын ачааллыг бууруулах.

2.Эрүүл мэндийн даатгалын сангийн үйл ажиллагааг сайжруулах, иргэдэд ил тод, нээлттэй болгох, хяналтыг сайжруулах, сангийн тэнцлийг хангах хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар (Ц.Батбаатар)-т даалгасугай:

2.1.Эрүүл мэндийн даатгалын сангийн орлогыг нэмэгдүүлэх хувилбарын тооцооллыг хийж, 2027 оны төсвийн төлөвлөлтийг актуар тооцоололд үндэслэн боловсруулж, бодитой төлөвлөж, хэлэлцүүлэх;

2.2.эмнэлгийн нэмэлт тусламж, үйлчилгээ, эмийн жагсаалтад дүн шинжилгээ хийж, даатгалын багцаас тусад нь зохицуулах замаар хэмнэлт бий болгох, хэмнэлтийг нэн шаардлагатай тусламж, үйлчилгээнд чиглүүлж, хуваарилалтын үр ашгийг нэмэгдүүлэх;

2.3.иргэний авсан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, сангийн орлого, зарлага, эмнэлэгт олгосон санхүүжилт, эмнэлгийн үзүүлсэн үйлчилгээний чанар, үр дүн, гүйцэтгэлийн үзүүлэлтийг олон нийтэд ил тод болгох зорилгоор даатгалын цахим хяналтын самбар ажиллуулах арга хэмжээ авах.

3.Хувийн эрүүл мэндийн даатгал болон сайн дурын даатгалын бүтээгдэхүүний зохицуулалтыг боловсронгуй болгох замаар эрүүл мэндийн санхүүжилтийн эх үүсвэрийг төрөлжүүлэх, эрүүл мэндийн даатгалын хамрах хүрээ, төлбөрийн уялдаа, хамтын төлбөрийн зохицуулалтыг сайжруулах чиглэлээр эрх зүйн орчныг боловсронгуй болгох санал боловсруулж ажиллахыг Эрүүл мэндийн сайд Э.Батшугар, Сангийн сайд З.Мэндсайхан нарт даалгаж, Санхүүгийн зохицуулах хорооны дарга Т.Жамбаажамцад зөвлөсүгэй.

4.Эрүүл мэндийн салбарын ажилчдын ажлын гүйцэтгэл, үйл ажиллагааны үр дүнд суурилсан цалин урамшууллын тогтолцоог (KPI) боловсронгуй болгох бүтээмжид үндэслэсэн цалин нэмэгдүүлэх шийдлийг боловсруулах, холбогдох эрх зүйн орчныг бүрдүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Эрүүл мэндийн сайд Э.Батшугар, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аубакир нарт үүрэг болгосугай.

5.Эрүүл мэндийн салбарын цахим шилжилтийг эрчимжүүлж, 2026 онд багтаан олон улсын стандартад нийцсэн “Эрүүл мэндийн мэдээлэл, солилцооны нэгдсэн сан”-г байгуулж, иргэн бүрийг эрүүл мэндийн цахим карттай болгох, эрүүл мэндийн салбарын мэдээллийг бүх шатны байгууллагууд харилцан ашиглах боломжийг бүрдүүлэх, мэдээллийн аюулгүй байдал, нууцлалыг хангах, оношилгоо, эмчилгээний чанарыг сайжруулах, давхардсан үйлчилгээг арилгах, зардлыг бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд, шаардлагатай тоног төхөөрөмж, программ хангамжийн шийдлийг дэмжиж ажиллахыг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ч.Номинд даалгасугай.

6.Эмнэлгийн яаралтай түргэн тусламжийг улсын хэмжээнд нэгдсэн дуудлагын сүлжээнд оруулж, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах чиг үүрэг бүхий “Үндэсний түргэн тусламжийн төв” тусгай мэргэжлийн төвийг 2026 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс байгуулж, бэлтгэл ажлыг ханган 2027 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс үйл ажиллагааг нь эхлүүлэх арга хэмжээ авахыг Эрүүл мэндийн сайд Э.Батшугарт, төв байгуулахтай холбоотой өмчийн асуудлыг шийдвэрлэхийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Х.Нямбаатарт тус тус даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.УЧРАЛ

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД Э.БАТШУГАР